

## ХУРАЛДААНЫ ТОЙМ

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2015 ОНЫ ГУЧИН ДӨРӨВДҮГЭЭР ХУРАЛДААН

Хуралдаан 2015 оны арванхоёрдугаар сарын 03-ны 14 цаг 05 минутад эхэлж, 15 цаг 10 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, 1 цаг 05 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	<p>Хөдөлмөрийн яамны зарим удирдах албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p> <ul style="list-style-type: none"><li>- Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалд томилуулахаар</li><li>- Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлого зохицуулалтын газрын даргын албан тушаалд томилуулахаар</li></ul>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Батсүхийн Баянмөнхийг Хөдөлмөрийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, дүгнэлт гарган, Хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Р.Эрдэнэбүрэнд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p>

		<p>Батнямын Алтанжаргалыг Хөдөлмөрийн яамны Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлого зохицуулалтын газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, дүгнэлт гарган, Хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Р.Эрдэнэбүрэнд санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	<p>Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай/</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “б”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Батхүүгийн Ганхөлөгийг Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, дүгнэлт гарган, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Дэлгэрцогтод санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	<p>Дархан уул аймгийн Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай</p>	<p>Дархан-Уул аймгийн Засаг дарга А.Энхболдын 2015 оны 1-2033 тоот албан бичгээр Дархан уул аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах захиалга ирүүлснийг хэлэлцээд, сонгон шалгаруулалтыг 2015 оны 12 дугаар сарын 03-ноос эхлэн, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд, нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2015 оны 12 дугаар сарын 29-ний өдөр зохион</p>

		байгуулахаар шийдвэрлэлээ.
4	Нийслэл болон Сэлэнгэ, Хөвсгөл, Ховд, Баян-Өлгий аймгуудын нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог тус тус нөхөх төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын дүн	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар зүйлийг баримталж, 2015 оны 11 дүгээр сарын 09-19-ний өдрүүдэд Сэлэнгэ аймаг, Хөвсгөл аймаг, Ховд аймаг, Баян-Өлгий аймагт тус тус зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <p>1. Сэлэнгэ аймаг, Хөвсгөл аймаг, Ховд аймаг, Баян-Өлгий аймагт 2015 оны 11 дүгээр сарын 09-19-ний өдрүүдэд зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1, 2, 3, 4 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 187 иргэн /Сэлэнгэ аймагт 34, Хөвсгөл аймагт 11, Ховд аймагт 117, Баян-Өлгий аймагт 25/-ийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 5, 6, 7 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 154 иргэн /Сэлэнгэ аймагт 29, Хөвсгөл аймагт 110, Ховд аймагт 15/-ийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д тус тус бүртгэх</p> <p>2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 8, 9, 10, 11 дүгээр хавсралтад дурдсан нэр</p>

бүхий 45 иргэн /Сэлэнгэ аймагт 10, Хөвсгөл аймагт 6, Ховд аймагт 25, Баян-Өлгий аймагт 4/-ийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 12, 13, 14 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 52 иргэн /Сэлэнгэ аймагт 12, Хөвсгөл аймагт 29, Ховд аймагт 11/-ийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар тус тус нэр дэвшүүлэх

3. Энэхүү тогтоолын 8-14 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 97 нэр дэвшүүлсэн иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл /Ө.Сувдаа/-д, Төрийн албаны зөвлөлийн Хөвсгөл аймаг дахь салбар зөвлөл /Г.Төмөрбаатар/-д, Төрийн албаны зөвлөлийн Ховд аймаг дахь салбар зөвлөл /Б.Батмөнх/-д, Төрийн албаны зөвлөлийн Баян-Өлгий аймаг дахь салбар зөвлөл /Т.Манкей/-д үүрэг болгох

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 8 дугаар

		<p>зүйлийг баримталж, 2015 оны 11 дүгээр сарын 03-16-ны өдрүүдэд Нийслэлд зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 03 -ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <p>1. Нийслэлд 2015 оны 11 дүгээр сарын 03-16-ны өдрүүдэд зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн 1 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 234 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д, 2 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 231 иргэнийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д тус тус бүртгэх</p> <p>2. Энэхүү тогтоолын нэг дэх хэсэгт заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 3 дугаар хавсралтад дурдсан нэр бүхий 14 иргэнийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 4 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 3 иргэнийг өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар тус тус нэр дэвшүүлэх.</p> <p>3. Энэхүү тогтоолын 3, 4 дүгээр хавсралтад дурдсан нэр бүхий 17 нэр дэвшүүлсэн иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан</p>
--	--	---

		<p>шаардлагыг баримтлан, тухайн албан тушаалд томилуулах арга хэмжээ авахыг Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөл /Ё.Гэрэлчулуун/-д үүрэг болгох</p> <p>4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
--	--	--

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА**